

 SG INVESTMENT & SECURITIES

ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ 2023-IV

АГУУЛГА

| | | |
|-------|--|----|
| 1 | МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ..... | 4 |
| 1.1 | Дотоодын нийт бүтээгдэхүүн..... | 4 |
| 1.1.1 | Уул уурхайн салбар..... | 5 |
| 1.2 | Гадаад худалдаа..... | 6 |
| 1.2.1 | Экспортын гол бараанууд..... | 6 |
| 1.2.2 | Импортын гол бараанууд..... | 7 |
| 1.3 | Бодлогын хүү..... | 7 |
| 1.4 | Инфляц..... | 8 |
| 1.5 | Улсын төсөв..... | 9 |
| 1.5.1 | Төсвийн зарлага..... | 9 |
| 1.6 | Төсвийн орлого..... | 10 |
| 1.7 | Засгийн газрын гадаад өр..... | 11 |
| 1.8 | Гадаад валют..... | 12 |
| 1.8.1 | Гадаад валютын албан нөөц..... | 13 |
| 1.9 | Мөнгөний нийлүүлэлт..... | 13 |
| 1.10 | Төлбөрийн тэнцэл..... | 14 |
| 1.11 | Зээлжих зэрэглэл..... | 15 |
| 1.12 | Ажил эрхлэлт..... | 15 |
| 2 | ЭДИЙН ЗАСГИЙН ЦААШДЫН ТӨЛӨВ БАЙДАЛ..... | 16 |
| 2.1 | Дотоодын нийт бүтээгдэхүүний төсөөлөл..... | 16 |
| 2.2 | Инфляцын төсөөлөл..... | 16 |
| 2.3 | 2024 оны улсын төсөв..... | 17 |
| 2.3.1 | 2024 оны улсын төсвийн орлого..... | 18 |
| 2.3.2 | 2024 оны улсын төсвийн зардал..... | 19 |
| 2.3.3 | Төсвийн онцлох бодлогууд..... | 20 |

ГРАФИКЫН ЖАГСААЛТ

| | |
|--|----|
| График 1. Дотоодын нийт бүтээгдэхүүн, оны үнээр /тэрбум төг/..... | 4 |
| График 2. Нүүрсний экспорт /сая.тн/..... | 5 |
| График 3. Уул уурхайн зарим бүтээгдэхүүний олборлолт..... | 5 |
| График 4. Гадаад худалдаа /сая ам.доллар/..... | 6 |
| График 5. 2023 оны экспортын орлого /тэрбум ам.доллар/..... | 6 |
| График 6. 2023 оны импортын орлого /тэрбум ам.доллар/..... | 7 |
| График 7. Бодлогын хүү /хувиар/..... | 7 |
| График 8. Инфляцын түвшин/хувиар/..... | 8 |
| График 9. Улсын төсөв /их наяд төг/..... | 9 |
| График 10. Засгийн газрын нийт гадаад өр /их наяд төг/..... | 11 |
| График 11. 2023 оны засгийн газрын гадаад өрийн бүтэц /их наяд төг/..... | 12 |
| График 12. Ам.долларын ханш..... | 12 |
| График 13. ГВАН /сая ам.доллар/..... | 13 |
| График 14. Мөнгөний нийлүүлэлт /их наяд төг/..... | 13 |
| График 15. Мөнгөний нийлүүлэлтийн пассив хэсэг /их наяд төг/..... | 14 |
| График 16. Ажиллах хүчний тоо..... | 15 |
| График 17. ДНБ, төсөөлөл /өсөлтийн хувиар/..... | 16 |
| График 18. Төсвийн төсөөлөл /их наяд төг/..... | 17 |
| График 19. 2024 оны төсвийн орлогын задаргаа /их наяд төг/..... | 18 |
| График 20. 2024 оны төсвийн орлогын задаргаа /их наяд төг/..... | 19 |


ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|----|
| Хүснэгт 1 Салбаруудын хувь нэмэр /ДНБ оны үнээр, тэрбум төг/..... | 4 |
| Хүснэгт 2. Гол бараа, бүтээгдэхүүний инфляц /хувиар/..... | 8 |
| Хүснэгт 3 Нэгдсэн төсвийн нийт зарлага, эдийн засгийн салбараар /тэрбум төг/..... | 9 |
| Хүснэгт 4 Улсын төсвийн орлогын задаргаа /тэрбум төг/..... | 10 |
| Хүснэгт 5. Төлбөрийн тэнцэл /сая ам.доллар/..... | 14 |
| Хүснэгт 6. Ажиллагчид, эдийн засгийн салбараар..... | 15 |
| Хүснэгт 7. Төсвийн төсөөлөл /их наяд төг/..... | 17 |
| Хүснэгт 8. 2024 оны төсвийн орлогын задаргаа /их наяд төг/..... | 18 |
| Хүснэгт 9. 2024 оны төсвийн орлогын задаргаа /их наяд төг/..... | 19 |
| Хүснэгт 10. Халамжийн сангаас олгогдох нэмэгдсэн тэтгэмжүүд /тэрбум төг/..... | 19 |
| Хүснэгт 11. Улсын төсвийн зардал, эдийн засгийн салбараар /тэрбум төг/..... | 20 |

1 МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

1.1 Дотоодын нийт бүтээгдэхүүн

График 1. Дотоодын нийт бүтээгдэхүүн, оны үнээр /тэрбум төг/



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Хүснэгт 1 Салбаруудын хувь нэмэр /ДНБ оны үнээр, тэрбум төг/

| Бүрэлдэхүүн | 2023-IV | Өсөлтийн хувь |
|--|-----------|---------------|
| ДНБ | 68,871.74 | 27.9% |
| Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур | 7,019.62 | 0.1% |
| Уул уурхай, олборлолт | 19,439.08 | 56.7% |
| Барилга | 2,088.17 | 17.1% |
| Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ | 6,663.33 | 17.4% |
| Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 3,908.49 | 55.7% |
| Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 15,732.04 | 22.8% |
| Бүтээгдэхүүний цэвэр татвар | 6,708.28 | 16.6% |


Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйгаас бусад салбарууд эерэг нөлөө үзүүлжээ. Тухайлбал уул уурхай 56.7 хувиар, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 55.7 хувиар, бөөний болон жижиглэн худалдааны салбар 17.4 хувиар өссөн нь эдийн засгийн нийт өсөлтийг дэмжсэн.

Уул уурхайн салбарын түүхэн өсөлтийн нөлөөгөөр авто зам, төмөр замын ачаа эргэлт сайжирч, тээврийн салбарын өсөлтөд нөлөөлөв. Мөн уул уурхайн салбарын өсөлт автомашин болон жижиглэн худалдааны борлуулалт нэмэгдэхэд хөшүүрэг болжээ.

1.1.1 Уул уурхайн салбар


График 2. Нүүрсний экспорт /сая.тн/



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Гадаад валютын албан нөөц, экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн засгийн газрын бодлогын үр дүнд нүүрсний экспорт нэмэгдсэн. Мөн Гашуунсухайт, Замын-Үүд, Шивээхүрэн хилийн боомтуудад ухаалаг гарц болон нүүрсний шинжилгээний лаборатори, рентгений тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулж, биржээр ил тод нээлттэй нүүрс арилжаалдаг болсон нь нөлөөлжээ. Нүүрсний экспорт 2023 оны эцсийн байдлаар 69.6 сая тонн хүрч, өмнөх оноос 42 хувь, цар тахлын үеэс 2.2 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

График 3. Уул уурхайн зарим бүтээгдэхүүний олборлолт




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Уул уурхайн салбарын хувьд нүүрс олборлолтоос гадна зэс, жоншны хүдэр, боловсруулаагүй нефтийн олборлолт өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал зэсийн баяжмалын үйлдвэрлэл 1.5 сая тоннд хүрч, 2022 оноос 4.9 хувь өссөн ба дэлхийн зах зээлд зэсийн эрэлт нэмэгдсэн нь өсөлтийн шалтгаан болов. Газрын тос буюу боловсруулаагүй нефтийн хувьд 2022 онд хилийн боомтын үйл ажиллагааны хязгаарлалтаас хамааран экспорт болон олборлолтын үйл ажиллагаа зогссон билээ.

Харин 2023 онд хилийн боомтын үйл ажиллагаа сэргэж 4.7 сая баррель газрын тос экспорт хийжээ. Мөн жоншны хүдрийн олборлолт 1 сая тонн хүрч, 180 хувиар өсөв.

1.2 Гадаад худалдаа

График 4. Гадаад худалдаа /сая ам.доллар/




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Экспортын орлого нэмэгдэж, гадаад худалдааны тэнцэл 5 тэрбум ам.долларын ашигтай гарахад нүүрсний экспорт 69.6 сая тонн болж өссөн хамгийн гол нөлөөг үзүүлсэн. Импортын тухайд 9 тэрбум ам доллар гарч өмнө оноос 6 хувиар нэмэгдсэн ба уул уурхайн салбарын өсөлтийн үр дүнд тоног, төхөөрөмж, машин техник хэрэгсэл, нефтийн импорт өссөн ба цаашид ч өсөх хандлагатай байна.

1.2.1 Экспортын гол бараанууд

График 5. 2023 оны экспортын орлого /тэрбум ам.доллар/



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий газар

Уул уурхайн бүтээгдэхүүн 2023 онд экспортын 87 хувийг бүрдүүлжээ. Түүнчлэн нүүрсний экспорт дан ганцаараа 58 хувийг бүрдүүлсэн үзүүлэлттэй гарсан. Уул уурхайн бус бүтээгдэхүүний хувьд

ноолуур 359 ам.доллар, мах 314 сая ам.доллар, самар 160 сая ам.долларын экспортын орлого хийжээ. Монгол Улс дэлхийн 81 оронд бараа экспортолсноос БНХАУ-д 91.2 хувь, Швейцар 4.4 хувь, БНСУ-д нэг хувь тус тус ногдож нийт экспортын 96.6 хувийг тус орнууд эзэлсэн байна.

1.2.2 Импортын гол бараанууд

График 6. 2023 оны импортын орлого /тэрбум ам.доллар/




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Импортын орлого 9.2 тэрбум ам.долларт хүрсэн. Үүний 12 хувь ба 1.11 тэрбум ам.долларыг дизель түлш, 7.32 хувийг буюу 0.68 тэрбум ам.долларыг хөнгөн тэрэг, эзэлж байгаа бол автобензин 5.65 хувь бөгөөд 0.20 тэрбум ам.долларыг эзэлсэн үр дүнтэй гарлаа. Монгол Улсын 2023 оны импортын бараа бүтээгдэхүүний БНХАУ 40.6 хувь, ОХУ 25.7 хувь, Япон 7.8 хувь, БНСУ 4.5 хувь, АНУ 3.1 хувь, ХБНГУ 2.3 хувийг тус тус эзэлж, нийт импортын 84.0 хувийг бүрдүүлж байна.

1.3 Бодлогын хүү

График 7. Бодлогын хүү /хувиар/




2022 оны 12 дугаар сараас хойш бодлогын хүү 13 хувь байгаа бөгөөд өнгөрөгч онд инфляц буурсан ч бодлогын хүү буураагүй. Үүнд нь төсвийн зардлын өсөлт, цалин, тэтгэврийн өсөлт ирэх онд

үргэлжлэхээр байгаа нь эрэлтийн нөлөөг нэмэгдүүлж байгаа нь бодлогын хүү буурахгүй шалтгаан болж байна.

1.4 Инфляц

График 8. Инфляцын түвшин/хувиар/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Инфляцын түвшин 2023 оны турш бага багаар буурч оны төсгөлд 7.9 хувьтай гарсан ба өмнө оны эцсээс 5.2 хувиар буурч зорилтот түвшинд хүрлээ. Үүнд импортын барааны инфляц буурсан, мөн гадаад валютын нөөц нэмэгдэж, төгрөгийн ханш тогтворжсон нь гол хөшүүрэг болов. Дэлхийн зах зээлд цар тахлын үетэй харьцуулахад хүнсний үнэ буурч, тээвэр ложистик, хил гаалийн байдал сэргэсэн нь инфляц нэг оронтой тоо руу ороход нөлөөлжээ. Түүнчлэн Монголбанк инфляцыг дунд хугацаанд жилийн 6 хувь орчимд, +/-2 хувийн интервалд тогтворжуулахыг зорьж ажиллаж байна.

Хүснэгт 2. Гол бараа, бүтээгдэхүүний инфляц /хувиар/


| | 2020 | 2021 | 2022 | 2023 |
|--|------|------|------|------|
| Ерөнхий индекс | 2.3 | 13.8 | 13.2 | 7.9 |
| Хүнсний бараа, ундаа, ус | 9 | 21 | 15.4 | 12.2 |
| Согтууруулах ундаа, тамхи | 3.5 | 5 | 8.1 | 5.7 |
| Хувцас бөс бараа, гутал | 3.2 | 5.6 | 18.5 | 6.3 |
| Орон сууц, ус, цахилгаан, түлш | -6.1 | 14.4 | 15.4 | 4.3 |
| Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа | 2.4 | 9 | 14.7 | 6.4 |
| Эм, тариа эмнэлгийн үйлчилгээ | 3.7 | 9 | 17.4 | 7.5 |
| Тээвэр | -1.5 | 23.3 | 6.2 | 0.5 |
| Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ | 0 | 1.2 | 2.2 | 0 |
| Боловсролын үйлчилгээ | 0.4 | 4 | 6.7 | 16.8 |
| Зочид буудал, зоогийн газар, дотуур байр | 6.4 | 16 | 15.1 | 16 |
| Даатгал, санхүүгийн үйлчилгээ | 0 | 7.1 | 3.7 | 6.7 |
| Бусад бараа, үйлчилгээ | 4.7 | 9.6 | 21.3 | 17.3 |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2023 онд боловсролын үйлчилгээ буюу сургуулиудын сургалтын төлбөрөөс бусад бүх гол бараа бүтээгдэхүүний инфляц буурсан байна.

1.5 Улсын төсөв

График 9. Улсын төсөв /их наяд төг/



2022 оноос эхлэн Монгол Улсын эдийн засаг сэргэж, улсын төсвийн тэнцэл эерэг гарсан ба 2023 онд төсвийн орлого 24.31 их наяд төгрөг гарч, төсвийн тэнцэл 1.86 их наяд төгрөг гарсан үзүүлэлттэй байна.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

1.5.1 Төсвийн зарлага

Хүснэгт 3 Нэгдсэн төсвийн нийт зарлага, эдийн засгийн салбараар /тэрбум төг/

| ҮЗҮҮЛЭЛТ | 2022 оны гүйц | 2023 оны урьдчилсан гүйцэтгэл | | | |
|--|-----------------|-------------------------------|-----------------|-------------|-----------------|
| | | Төл | Гүйц | Хувь | Зөрүү |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 18,159.7 | 24,228.9 | 22,454.5 | 92.7 | -1,774.5 |
| НИЙТ ЗАРЛАГА | 18,032.7 | 24,289.0 | 22,221.5 | 91.5 | -2,067.5 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 14,229.3 | 18,071.4 | 17,046.6 | 94.3 | -1,024.8 |
| БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,806.0 | 5,475.1 | 5,062.1 | 92.5 | -413.0 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,666.3 | 2,422.0 | 2,321.7 | 95.9 | -100.2 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 318.2 | 431.4 | 387.4 | 89.8 | -44.0 |
| Хангамж, бараа материалын зардал | 182.3 | 218.1 | 206.2 | 94.5 | -11.9 |
| Нормативт зардал | 229.3 | 229.0 | 226.5 | 98.9 | -2.5 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 121.3 | 169.4 | 159.7 | 94.2 | -9.7 |
| Томилолт, зочны зардал | 28.7 | 60.6 | 49.5 | 81.7 | -11.1 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 784.8 | 1,136.3 | 1,003.6 | 88.3 | -132.7 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 475.1 | 808.2 | 707.3 | 87.5 | -100.8 |
| ХҮҮ | 797.8 | 1,151.6 | 1,131.7 | 98.3 | -19.6 |
| ТАТААС | 537.1 | 797.8 | 579.7 | 72.7 | -218.1 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 9,088.5 | 10,646.9 | 10,273.1 | 96.5 | -373.8 |
| Засгийн газрын урсгал шилжүүлэг | 4,711.9 | 3,673.2 | 3,594.3 | 97.8 | -79.0 |
| Бусад урсгал шилжүүлэг | 4,376.6 | 6,973.6 | 6,678.8 | 95.8 | -294.8 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 3,803.4 | 6,217.6 | 5,174.9 | 83.2 | -1,042.7 |

| | | | | | |
|--|-------|-------|-------|--------|-------|
| ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 127.0 | -60.0 | 233.0 | -388.1 | 293.0 |
|--|-------|-------|-------|--------|-------|

Эх сурвалж: Сангийн яам

2023 оны улсын төсвийн нийт зарлага 914.8 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдаж 94.6 хувийн гүйцэтгэлтэй гарчээ. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнд урсгал зардлын эзлэх хувийн жин 75.9 хувьд хүрсэн ба өмнө оны мөн үеэс 27 хувь өсөн 18 их наяд төгрөгт хүрчээ.



2022 онтой харьцуулахад 2023 онд нэгдсэн төсвийн урсгал зардал 2.8 их наяд нэмэгдсэн байна. Үүнд татаас 42.6 тэрбум төгрөгөөр, урсгал шилжүүлэг 1.18 их наяд төгрөг, бараа, ажил үйлчилгээний зардал 1.26 их наяд төгрөг, зээлийн үйлчилгээний төлбөр 333.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ.

1.6 Төсвийн орлого

Хүснэгт 4 Улсын төсвийн орлогын задаргаа /тэрбум төг/

| Үзүүлэлт | 2022 | 2023 |
|---------------------------------------|-----------------|-----------------|
| Нийт орлого ба тусламжийн дүн | 18,593.1 | 24,310.1 |
| Ирээдүйн өв сан | 0.0 | 416.2 |
| Тогтворжуулалтын сан | 1,394.6 | 675.9 |
| Татварын орлого | 15,568.3 | 21,450.8 |
| Орлогын албан татвар | 3,946.8 | 5,799.8 |
| Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар | 2,642.5 | 4,002.0 |
| Хувь хүний орлогын албан татвар | 1,355.3 | 1,861.8 |
| Нийгмийн даатгалын орлого | 3,027.0 | 3,942.8 |
| Хөрөнгийн/өмчийн албан татвар | 234.8 | 396.9 |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар | 3,918.6 | 4,773.4 |
| Онцгой албан татвар | 847.8 | 790.0 |
| Тусгай зориулалтын орлого | 19.4 | 21.6 |
| Гадаад үйл ажиллагааны орлого | 1,292.2 | 1,464.1 |
| Бусад татвар | 2,281.8 | 4,262.2 |
| Татварын бус орлого | 1,630.2 | 1,767.2 |


| | | |
|-----------------------------|---------|---------|
| Нийтлэг татварын бус орлого | 1,327.2 | 1,430.1 |
| ХӨРӨНГИЙН ОРЛОГО | 3.5 | 7.5 |
| Тусламжийн орлого | 299.5 | 329.5 |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Улсын төсвийн орлого өмнө оны мөн үеэс 31 хувиар нэмэгдэж, 24.3 их наяд төгрөг давсан үзүүлэлттэй байна. Орлогын 92.4 хувийг татварын орлого, 7.6 хувийг татварын бус орлого эзэлсэн. Түүнчлэн 2022 онтой харьцуулахад татварын орлого 38.8 хувь буюу 1,704.0 тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 5.9 хувь буюу 99.2 тэрбум төгрөгөөр өссөн байна. Татварын орлогын 27.0 хувийг орлогын албан татвар, 18.4 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.9 хувийг хөрөнгийн албан татвар, 22.3 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 3.7 хувийг онцгой албан татвар, 0.1 хувийг тусгай зориулалтын орлого, 6.8 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 19.9 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлэв.

1.7 Засгийн газрын гадаад өр

График 10. Засгийн газрын нийт гадаад өр /их наяд төг/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Засгийн газрын гадаад 2023 онд 3.7 хувиар өссөн ба 34.6 их наяд төгрөгт хүрсэн.

Өнгөрөгч онд засгийн газрын төлсөн гадаад өр төлбөрүүд:

- 2023 оны 5 дугаар сард Гэрэгэ бондын 540 сая ам.доллар
- 2023 оны 9 дүгээр сард Евро бондын 500 сая ам.доллар
- 2023 оны 12 дугаар сард Самурай бондын 223 сая ам долларын төлбөрүүдийг төлсөн байна.

Харин БНХАУ-ын Ардын Банкнаас авсан своп хэлцлийн 2.2 тэрбум ам.долларын төлбөрийг 2026 он луу шилжүүлсэн. Ирэх жилүүдэд бондын эргэн төлөлт байхгүй учраас Монгол Улсын зээлжих зэрэглэл нэмэгдэх магадлалтай байна.


График 11. 2023 оны засгийн газрын гадаад өрийн бүтэц /их наяд төг/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

1.8 Гадаад валют

График 12. Ам.долларын ханш




Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн хувьд 2023 оны эхэнд ам.долларын албан ханш 3,444₮ байсан бол, оны эцэст 3,410₮ болж 0.9% хувиар чангарчээ. 2023 оны гуравдугаар сарын 17-нд ам.долларын ханш 3528₮ болж түүхэн дээд хэмжээнд хүрсэн. Өнгөрсөн онд экспортын орлого нэмэгдэж, эдийн засаг сэргэж эхэлснээр ам.долларын ханш аажмаар буурч байгаа ба цаашид ч буурах хандлагатай байна.

1.8.1 Гадаад валютын албан нөөц

График 13. ГВАН /сая ам.доллар/




Эх сурвалж: Монголбанк

Гадаад валютын албан нөөц 2023 онд 1.4 тэрбум ам.доллараар нэмэгджээ. 2022 онд экспортын орлого буурсны улмаас гадаад валют хомсдолд орж албан нөөц 2.7 тэрбум ам.доллар хүртэл буурсан. Харин өнгөрөгч онд экспортын орлого, нүүрсний экспортын түүхэн амжилтын нөлөөгөөр гадаад валютын албан нөөц 2021 оны 5 дугаар сараас хойш анх удаа 4.9 тэрбум ам.долларыг давав.

1.9 Мөнгөний нийлүүлэлт


График 14. Мөнгөний нийлүүлэлт /их наяд төг/



Эх сурвалж: Монголбанк

2023 онд мөнгөний нийлүүлэлт 37 их наяд төгрөгт хүрч өмнө оны эцсээс 27 хувь өссөн. Мөнгөний нийлүүлэлт өсөхөд экспортын сэргэлт, инфляцын бууралт, гадаад валютын албан нөөцийн өсөлт, зээл олголт нэмэгдсэн мөн эх үүсвэр өссөн зэрэг нь гол хөшүүрэг болжээ.

График 15. Мөнгөний нийлүүлэлтийн пассив хэсэг /их наяд төг/



Эх сурвалж: Монголбанк

Мөнгөний нийлүүлэлт өсөхөд эх үүсвэр буюу пассив талын харилцах, хадгаламжийн дүн нийлбэр дүнгээрээ өмнө оны мөн үеэс 27 хувь өссөн гол нөлөөг үзүүлсэн. 2023 оны байдлаар төгрөгийн харилцахын хувьд 8.9 их наяд төгрөг, төгрөгийн хадгаламж 17.1 их наяд төгрөг, валютын хадгаламж 5.0 их наяд төгрөг, валютын харилцах 5.6 их наяд төгрөг байна. Долларын ханш 2023 оноос эхлэн бага багаар суларч байгаатай холбоотойгоор төгрөгийн харилцах болон хадгаламж өсөх хандлагатай байна.

1.10 Төлбөрийн тэнцэл

Хүснэгт 5. Төлбөрийн тэнцэл /сая ам.доллар/

| Үзүүлэлт | Он | | | Өөрчлөлт Дүн |
|-------------------------|-----------|-----------|-----------|-----------------|
| | 2021 | 2022 | 2023 | |
| Урсгал данс | (2,108.4) | (2,305.5) | 244.5 | 2,548.0 |
| Хөрөнгийн данс | 114.0 | 154.2 | (135.6) | (18.7) |
| Санхүүгийн данс | (1,982.2) | (1,644.1) | (1,376.0) | 268.0 |
| Алдаа болон орхигдуулаг | (209.4) | (222.1) | (299.2) | (77.1) |
| Нөөц хөрөнгө | (221.6) | (727.2) | 1,457.0 | 2,184.3 |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2022 оны эцэст 2.3 тэрбум ам.долларын алдагдалтай байсан бол 2023 оны онд 244.5 сая ам.долларын ашигтай гарсан. Урсгал данс ашигтай гарахад барааны худалдааны экспорт нэмэгдэж, гадаад худалдааны тэнцэл 4.4 тэрбум ам.долларын ашигтай гарсан нь нөлөөлсөн байна.

1.11 Зээлжих зэрэглэл

S&P Global В/тогтвортой

FitchRatings В/тогтвортой


MOODY'S В3/тогтвортой

Эх сурвалж: Сангийн яам

2023 онд Зээлжих зэрэглэл тогтоодог олон улсын томоохон гурван агентлаг болох "Standard & Poor's" (S&P), "Fitch" агентлаг В/тогтвортой, "Moody's" агентлаг В3/тогтвортой гэсэн үнэлгээг Монгол Улсын Хөгжлийн Банканд өгсөн байна

1.12 Ажил эрхлэлт

График 16. Ажиллах хүчний тоо



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Ажиллах хүчний 1.2 сая нь буюу 96.1 хувь нь ажиллагчид, 48.8 мянга ба 3.9 хувь нь ажилгүй хүн байна. Ажиллагчид 2022 оны үеэс 38.6 мянгаар, өмнөх улирлаас 3.5 мянгаар өсөж, ажилгүй хүн 2022 оноос 15.8 мянгаар, 3-р улирлаас улирлаас 17.2 мянгаар буурсан байна. Эдийн засгийн салбаруудын үйл ажиллагаа сэргэж ажилгүйдлийн түвшин буурч байгаа хэдий ч хөдөлмөрийн зах зээл цар тахлын өмнөх буюу 2019 оны ажиллах хүчний түвшиндээ хүрээгүй хэвээр байна. Хүснэгт

Хүснэгт 6. Ажиллагчид, эдийн засгийн салбараар


| Салбар | Ажилчдын тоо | Нийт ажиллагчдад эзлэх хувь |
|--|--------------|-----------------------------|
| Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт | 261,677 | 22% |
| Боловсруулах үйлдвэрлэл | 119,583 | 10% |
| Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ | 168,846 | 14% |
| Боловсрол | 121,783 | 10% |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2 ЭДИЙН ЗАСГИЙН ЦААШДЫН ТӨЛӨВ БАЙДАЛ


2.1 Дотоодын нийт бүтээгдэхүүний төсөөлөл

График 17. ДНБ, төсөөлөл /өсөлтийн хувиар/



Дэлхийн болон дотоодын томоохон санхүүгийн байгууллагууд Монгол Улсын 2024 оны эдийн засгийн өсөлтийг 4.5-6.4 хувь гэж таамагласан байна. 2023 онд Монгол Улсын эдийн засаг 7 хувийн өсөлт үзүүлсэн бөгөөд уг өсөлт нь БНХАУ-ын экспортын нүүрсний эрэлт их байсантай шууд холбоотой билээ. БНХАУ-ын дотоодын нүүрсний олборлолт сэргэж эхэлсэн, мөн сонгуулийн жилийн төсвийн тэлэлт нь экспортын өсөлтийг бууруулж импортын өсөлтийг нэмэгдүүлж эдийн засгийн өсөлтийг хойшоо татах хандлагатай байна.


2.2 Инфляцын төсөөлөл



2023 онд инфляц 7.9 хувьтай гарсан ба дэлхийн болон дотоодын санхүүгийн байгууллагууд 2024 оны инфляцыг 8.5-9.1 хувьтай байна гэж таамаглаж байна. 2024 онд төсвийн зардал нэмэгдэх, төрийн албан хаагчдын цалин болон тэтгэвэр тэтгэмж нэмэгдэх нь инфляцын бууралтыг саармагжуулах хандлагатай байна. Мөн БНХАУ-ын нүүрсний экспортын эрэлт багасаж байгаа инфляцын төсөөлөлд сөргөөр нөлөөлж байна.

2.3 2024 оны улсын төсөв

График 18. Төсвийн төсөөлөл /их наяд төг/



Эх сурвалж: Сангийн яам

Хүснэгт 7. Төсвийн төсөөлөл /их наяд төг/

| № | Эдийн засгийн үндсэн үзүүлэлт | 2024 он | 2025* | 2026* |
|---|---|---------|-------|-------|
| 1 | Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ | 6.27 | 6.62 | 6.97 |
| | ДНБ-д эзлэх хувь | 8.5 | 8 | 7.7 |
| 2 | Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр | 44.4 | 49.8 | 54.0 |
| | ДНБ-д эзлэх хувь | 60 | 60 | 60 |
| 3 | Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ | 2.35 | 2.43 | 2.46 |
| | ДНБ-д эзлэх хувь | .3.2 | 2.9 | 2.7 |

Эх сурвалж: Сангийн яам

2024 оны улсын төсөв 27.4 их наяд төгрөгийн зардалтай, орлого 25.9 наяд их төгрөгийн орлоготой 1.5 их наяд төгрөгийн алдагдалтай батлагдлаа. 2024 оны зардлын тэлэлтэд нийгмийн даатгалын сангийн тэтгэмж, тэтгэврийн зардал, мөн төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэн нь гол нөлөөг үзүүллээ. Харин орлогын хувьд нүүрсний экспортын хэмжээтэй шууд хамааралтай билээ. 2023 онд Монгол Улс нүүрсний экспортын хувьд түүхэн дээд амжилтаа үзүүлсэн бөгөөд 70 сая тонн болсон. 2024 оны улсын төсвийн төлөвлөгөөгөөр 60 сая тонн экспортлохоор төлөвлөсөн ба үүнд БНХАУ-ын нүүрсний дотоод олборлолт нэмэгдэж эхэлсэнтэй нь холбоотой байна.

2.3.1 2024 оны улсын төсвийн орлого

График 19. 2024 оны төсвийн орлогын задаргаа /их наяд төг/



Эх сурвалж: Сангийн яам


Хүснэгт 8. 2024 оны төсвийн орлогын задаргаа /их наяд төг/

| Ангилал | 2023 | 2024 | Өсөлт |
|--|-------|--------|--------|
| Нийт орлого ба тусламжийн дүн | 24.31 | 25.86 | 6.4% |
| Татварын орлого | 21.45 | 23.95 | 11.7% |
| Орлогын албан татвар | 5.80 | 5.73 | -1.2% |
| Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар | 4.00 | 4.02 | 0.3% |
| Хувь хүний орлогын албан татвар | 1.86 | 1.71 | -7.9% |
| Нийгмийн даатгалын сангийн орлого | 3.94 | 5.05 | 28.1% |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого | 1.59 | 1.96 | 23.2% |
| Хөрөнгийн/өмчийн албан татвар | 0.40 | 0.2375 | -40.2% |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар | 4.77 | 6.18 | 29.5% |
| Онцгой албан татвар | 0.79 | 0.991 | 25.4% |
| Тусгай зориулалтын орлого | 0.02 | 0.028 | 29.5% |
| Гадаад үйл ажиллагааны орлого | 1.46 | 1.93 | 31.7% |
| Бусад татвар | 4.26 | 3.81 | -10.7% |
| Татварын бус орлого | 1.77 | 1.90 | 7.6% |

Эх сурвалж: Сангийн яам

2.3.2 2024 оны улсын төсвийн зардал

График 20. 2024 оны төсвийн орлогын задаргаа /их наяд төг/



Эх сурвалж: Сангийн яам

Хүснэгт 9. 2024 оны төсвийн орлогын задаргаа /их наяд төг/

| ҮЗҮҮЛЭЛТ | 2023 гүйц | 2024 бат | Хувь |
|--|-----------|----------|------|
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 22.45 | 27.36 | 22% |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 17.05 | 21.22 | 24% |
| БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 5.06 | 8.88 | 75% |
| Нийгмийн даатгалын сангийн зардал | 4.03 | 5.19 | 29% |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн зардал | 1.60 | 1.85 | 16% |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2.32 | 5.52 | 138% |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 2.7403 | 3.37 | 23% |
| ТАТААС | 0.5797 | 0.6228 | 7% |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 10.27 | 10.54 | 3% |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 5.17 | 6.27 | 21% |
| ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | -0.233 | -0.135 | -42% |

Эх сурвалж: Сангийн яам

Төсвийн урсгал зардлын 60 гаруй хувийг нийгмийн даатгалын сангаас иргэдэд олгодог тэтгэвэр тэтгэмж, нөхөн олговор болон төрийн албан хаагчдын цалингийн дүн эзэлж байна. Түүнчлэн 2024 онд урсгал зардлын 24 хувийн өсөлтөд нийгмийн даатгалын сангийн зардлын өсөлт, төрийн албан хаагчдын цалингийн өсөлт, бараа ажил үйлчилгээний зардал нөлөөлжээ.

Хүснэгт 10. Халамжийн сангаас олгогдох нэмэгдсэн тэтгэмжүүд /тэрбум төг/

| Халамжийн сангаас олгогдох тэтгэмжүүд | 2024 бат | Өсөлтийн хувь |
|---------------------------------------|----------|---------------|
| Халамжийн тэтгэвэр | 279 | 14.2 |
| Асаргааны тэтгэмж | 201.6 | 59 |
| Амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж | 82.9 | 46.4 |

Эх сурвалж: Сангийн яам

Хүснэгт 11. Улсын төсвийн зардал, эдийн засгийн салбараар /тэрбум төг/

| Эдийн засгийн салбар | 2024 бат | Өсөлтийн хувь |
|------------------------------|----------|---------------|
| Боловсрол | 4,228 | 36.1 |
| Хүнс, ХАА, хөнгөн үйлдвэрлэл | 589 | 22.1 |
| Хөдөлмөр, нийгмийн хамгаалал | 3,922 | 21.6 |
| Эрүүл мэнд | 1,634 | 22.4 |
| Соёл | 398 | 25.5 |
| Олимп, нийтийн бие тамир | 145 | 29.2 |

Эх сурвалж: Сангийн яам

2.3.3 Төсвийн онцлох бодлогууд

- Цалин, тэтгэвэр, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлнэ.
 - Тэтгэвэр 100,000 төгрөгөөр нэмэгдүүлнэ.
 - Төрийн албан хаагчдын цалинг ажиллах нөхцөл, байршлыг харгалзан 10-40 хувиар нэмэгдүүлнэ.
 - Төсвийн урсгал зардал 21.3 их наяд төгрөг бөгөөд 60 хувийг нь тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгө, халамж болон төрийн албан хаагчдын цалинд зарцуулна.
- Нийт төсвийн хөрөнгө оруулалтын 79 хувь буюу 2.6 их наяд төгрөгийг хотын хүн амын төвлөрлийг сааруулахад чиглэсэн дэд бүтэц, зам тээврийн төслүүдэд зарцуулна.
- Улсын хэмжээнд олгож буй ипотекийн зээлийн 60 хувийг хөдөө орон нутагт хуваарлина.
- 60 сая тонн нүүрс, 1.5 сая тонн зэсийн баяжмал, төмрийн хүдэр 8.4 сая тонн, газрын тос 4.8 сая тонн баррель, алт 20 тонн тус тус экспортлохоор төлөвлөж уул уурхайн экспортын орлого 8 их наяд төгрөг болно.
- Монгол Улсын хэмжээнд 2024 онд улсын төсвийн хөрөнгөөр нийт 1050 төслийг хэрэгжүүлэх бөгөөд 552 нь он дамжин шилжиж хэрэгжих төсөлд 1.5 их наяд төгрөг, шинээр хэрэгжих 498 төсөлд 1.6 их наяд төгрөг зарцуулна.